

Бурханы өмнө бидний хүлээсэн үүрэг: Өсвөр үеийнхний эцэг эх, удирдагчдын үүрэг зорилго

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Роберт Д.Хейлс

Сайн мэдээг хувиараа гүнзгий судалж, ойлгон, үүнд итгэдэг байхад залуучуудад туслах нь бидний хойшлуулшгүй үүрэг мөн.

Дэлхий дахины өсвөр үеийнхний эцэг эх болон тэднийг удирдаж, үйлчлэхээр дуудагдсан бүх хүмүүст би өнөөдөр урам хайрлахыг хүсч байна. Их Эзэн Иосеф Смитэд “өсч өндийн байгаа бүх үеийнхэнд заавал биелүүлэх бидний үүргийг” илчилсэн юм. (С ба Г 123:11).

Эцэг болон өвөө хүний хувьд, би өсвөр үеийнхний төлөө Бурханы өмнө ямар үүрэг хүлээсэн бэ? гэсэн асуултыг амьдралынхаа турш эргэцүүлэн бодсоор ирсэн. Хувийн тунгаан бодолт, гэрчлэлийн үр дүнд сурсан зүйлээ би та нартай хуваалцахыг хүсч байна.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь удирдагч, эцэг эхчүүд бидний хувьд үлгэр жишээ үзүүлэхээс эхэлдэг. Энэ бол гэр орондоо сайн мэдээгээр байнга, тууштай амьдрах явдал мөн. Ингэхийн тулд өдөр бүр шаргуу хичээн чармайх хэрэгтэй.

Сайн мэдээ бидний амьдралд хэрхэн хэрэгжиж байгааг харахаас илүү чухал зүйл өсвөр үеийнхэнд байхгүй билээ. Эцэг эхийнхээ итгэдэг зүйлд Хиламаны залуу дайчид өчүүхэн ч эргэлздэггүй байлаа. “Эхчүүд маань үүнийг мэдэж байсан гэдэгт бид эргэлзэхгүй байна” (Алма 56:47-48-ыг үз) гэж тэд хэлсэн байдаг. Бидний мэддэг зүйлсийг хүүхдүүд маань ч мэддэг шүү дээ.

Нэг удаа ач хүү маань олон нийтэд танил болсон хэдий ч зохимжгүй киног хамт явж үзэхийг надаас гуйхад би түүнд, “Би тэр киног үзэх насанд хүрээгүй шүү дээ” гэв. Эмээ нь учрыг тайлбарлаж өгөх хүртэл ач хүү маань насны ялгаа эмээд нь хамаагүйг ойлгосонгүй. Ач хүү маань над уруу буцаж ирээд, “Аан, одоо л ойлголоо, Өвөө та энэ киног үзэх насанд хэзээ ч хүрэхгүй юм байна ш дээ, тийм үү?” гэв. Түүний зөв байлаа!

Үлгэр жишээгээр замыг нь харуулахаас гадна, өсвөр үеийнхний зүрх сэтгэлийг ойлгож, сайн мэдээний замаар мөр зэрэгцэн алхсанаар бид тэднийг үлгэрлэн

дагуулдаг. Хүүхдүүдийнхээ дотоод ертөнцийг жинхэнэ ёсоор ойлгохын тулд зөвхөн нэг өрөөнд цуг байж, гэр бүлийн болон Сүмийн үйл ажиллагаанд хамт оролцох нь хангалтгүй юм. Бид тэдний оюун бодол, зүрх сэтгэлд хоногшин, удаан хугацаанд нөлөөлөх заах боломжуудыг төлөвлөж, ашиглах ёстой.

Жишээ нь, Сүмийн удирдагчид санваартны болон скаутын үйл ажиллагаа, аялал зугаалга зэргийг тогтмол төлөвлөдөг. Гэвч эдгээр үйл ажиллагаа хамгийн чухал зорилгоо үргэлж биелүүлдэг үү? Санваартны болон Скаутын үйл ажиллагаанаас хөвгүүдэд хамгийн чухал зүйл нь шагналын тэмдгүүдээ авахаас гадна, өөрт нь болон амьдралд нь санаа тавьдаг удирдагчтайгаа тухтай сууж ярилцах явдал юм.

Үүнтэй адилаар, аав, ээжүүд та нар хүүхдүүдээ хичээл сургууль, бусад үйл ажиллагаанд хүргэж өгөхөөр явахдаа энэ цагийг ашиглан тэдний итгэл найдвар, хүсэл мөрөөдөл, айдас түгшүүр, баяр баясгалангийнх нь талаар ярилцдаг уу? Өөрийг тань сонсож, хайрыг тань хүүхдүүд чинь мэдрэхийн тулд тэдний MP3 тоглуулагч эсвэл бусад техник хэрэгслийг салгаж, ярилцахад цаг гаргадаг уу? Бага байхад минь тохиосон суралцах боломжууд, ялангуяа аав, ээжээсээ сурч мэдсэн зүйлс амьдралд минь нөлөөлж, намайг өдий зэрэгтэй болгосныг насны наран хэвийх тусмаа улам илүү ухаарч ойлгож байна.

Үр хүүхдийнхээ зүрх сэтгэлийг ойлгодог эцэг эхийн нөлөөг үнэлж баршгүй юм. Судалгаанаас үзэхэд, амьдралын хамгийн чухал шилжилтийн үед, өсвөр үеийнхэн Сүмээс амархан холдон хөндийрч мэдэх эгзэгтэй үед тэдэнд нөлөөлөх хамгийн хүчтэй нөлөө нь бишоптойгоо эсвэл өөр удирдагчтай хийх ярилцлага бус, харин эцэг эхтэйгээ ойр дотно, элэгсэг харилцаатай байж, хамтран ажиллах явдал мөн.

Энэ талаар бодож үзвэл, бид оройн хоол идэхээр суухдаа бүх гэр бүлээрээ хамт байдаг бил үү? Би бага байхдаа нэг оройн хоолны үеэр бейсбол тоглох зөвшөөрөл гуйснаа санаж байна. Би, “Миний хоолыг халаагчид үлдээчихээрэй” гэхэд ээж, “Роберт оо, чамайг түр завсарлаж, гэртээ ирж гэрийнхэнтэйгээ хамт хоолоо идэхийг би үнэхээр их хүсэж байна. Хоолны дараа харанхуй болтол бейсбол тогло л доо” гэж билээ. Гэр бүлээрээ цугтаа хоол идэхэд, хоол бус харин гэр бүлийн халуун дотно харилцаа бие, сэтгэлийг тэжээн тэтгэдэг юм гэж ээж сургаж билээ. Хамгийн их хайр энэрлийг хүн гэр дотроо л үзүүлж чадна гэж ээж минь хэлдэг байлаа.

Өсвөр үеийнхэнтэй харьцаж тэдний зүрх сэтгэлд нөлөөлөхийн тулд бид итгэл хүлээсэн насанд хүрсэн хамтран ажиллагч, дотны найздаа ханддаг шиг тэдэнд анхаарал, халамж тавих хэрэгтэй. Хамгийн чухал нь тэднээс асуулт асууж, ярилцан, ярьсныг нь нэг ч үг гээлгүй анхааралтайгаар сонсох тийм ээ, дахин дахин

сонсох-бүр сүнсний чихээрээ дахин сонсох хэрэгтэй! Хэдэн жилийн өмнө би сонин уншиж суутал бага насны нэг ач хүү минь миний дэргэд ирж суув. Ач маань ямар нэг юм хэлэх гээд байгааг сонсоход таатай байлаа. Хэдэн хоромын дараа ач маань сонин бид хоёрын дундуур шурган орж ирэхэд миний гайхсаныг яана. Ач маань миний нүүрийг гараараа барьж, хамраа миний хамарт тулгаад, “Өвөө, та энд байна уу?” гэв.

Ээж ээ, аав аа, та энд байна уу? Өвөө, эмээ, та энд байна уу? Энд байна уу гэдэг нь хүүхдийн зүрх сэтгэлийг ойлгож, тэдэнтэй байнга хамт байхыг хэлж байгаа юм. Хүүхдүүдтэй хамт байх гэдэг нь зөвхөн тэдэнтэй хамт байгаад зогсохгүй бас тэдэнтэй хамт аливаа юмсыг хийхийг хэлнэ.

Саяхан надад нэг ээж гурван охиныхоо Хувийн Хөгжил Дэвшлийн шаардлагуудыг хангахад өөрийн зүгээс хийх ёстой юмаа хийсэн тухайгаа ярив. Тэр эмэгтэй хөтөлбөрийн талаар мэдээлэлтэй байж, хөтөлбөрт гарын үсэг зурсан гэнэ. Тэрээр нүдэндээ нулимс цийлэгнүүлэн, цааш нь, “Саяхан би дөрөв дэх охиндоо энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд туслан, бүр өөрийн биеэр идэвхтэй оролцлоо. Ингэснээр бидний харилцаа болон амьдралд минь ч их өөрчлөлт гарлаа. Гэвч би ийм байдлаар нөгөө гурван охиндоо төслийг хэрэгжүүлэхэд нь тусалж идэвхтэй ажиллаж чадаагүйгээ ойлгон хэчнээн их харамссан гээч” гэж ярилаа. Хэлээр өгүүлж, үзгээр бичиж болох хамгийн гунигтай үгс бол “Тэгэх байсан юм даа, чааваас” гэсэн үгс юм!¹

Хувийн Хөгжил Дэвшил болон Бурханы өмнө хүлээх үүргээ биелүүлэх нь хөтөлбөрүүдийн шаардлагууд бол зүгээр нэг гүйцээсэн гэсэн тэмдэглэл хийх төдий урт жагсаалт биш гэдгийг насанд хүрсэн Сүмийн гишүүд ойлгох хэрэгтэй. Эдгээр хөтөлбөрүүд бол ариун сүмд орж ёслолуудыг хүртэх зохистой болох, мөнхийн гэрлэлт хийлгэх, номлолд үйлчлэх, өргөмжлөлийг хүртэх үйлст ахиц дэвшил гаргахад өөрсдөдөө туслах залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд нэг бүрийн хувийн зорилго юм. *Гэвч эдгээр зорилтуудыг биелүүлэхээр залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд зөвхөн өөрсдөө хичээнэ гэдэг бол их хохиролтой, эмгэнэлт хэрэг гэдгийг та бүхэн ойлгоно уу!*

Эцэг эхчүүд, залуучуудын удирдагчид та бүхнийг Хувийн Хөгжил Дэвшил болон Бурханы өмнө хүлээх үүргээ биелүүлэх нь хөтөлбөрт хүүхдүүдтэйгээ бас залуучуудтай хамт оролцдог байхыг бид хүсч байна. Зөвхөн хүүхдүүд тань төдийгүй, та нар өөрсдөө ч өсч хөгжих болно. Нөгөөтэйгүүр, хүүхдүүдтэйгээ харилцах ойр дотно харилцаа, итгэлийн хэлхээ холбоо тань бэхжих болно. Ингэснээр та бүхэн бие биедээ тусалж сайн мэдээний замаар мөнхийн гэр бүлээрээ үүрд хамтдаа замнах болно.

Эцэг эхчүүдийн хувьд Бурханы өмнө хүлээсэн бас нэгэн чухал үүрэг бол сайн мэдээг хүүхдүүддээ зааж, Аврагчийн сэргээгдсэн Сүмд бүрэн идэвхтэй байхад нь тэднийг бэлтгэх явдал юм. Бенжамин хааны ард түмэндээ өгсөн сургамжийг санагтун. Түүний сургаалын ачаар насанд хүрсэн олон хүнд зүрх сэтгэлийн хүчирхэг өөрчлөлт гарсан билээ (Мозая 5:2-ыг үз).

Гэвч “хаан Бенжаминны үгсийг ойлгож чадаагүй нь өсвөр үеийнхнээс олон байв, учир нь түүнийг өөрийн хүмүүст ярьж байх тэр цагт тэд бяцхан хүүхдүүд байжээ; мөн тэд . . . итгэсэнгүй . . . Мөн тэдний зүрх сэтгэл хатуурсан байв” (Мозая 26:1, 3) хэмээн өгүүлдэг.

Сайн мэдээг гүнзгий ойлгож, итгэлийг нь бат бөх төлөвшүүлэхэд бид өсвөр үеийнхэнд заавал туслах ёстой. Бид тэдэнд гэрэлд алхахыг зааж чадна. Харин тэрхүү гэрэл нь бусдын гэрэл байж болохгүй. Тэд үүнийг өөрсдөө олж авах ёстой. Тэд энэ гэрчлэлийнхээ гэрлийг сүнслэг гэрлийн эх сурвалж- Бурханаас Өөрөөс нь залбирал, судар судлах болон тунгаан бодолтоор дамжуулан авах ёстой. Тэд хэн бэ гэдгээ, Тэнгэрлэг Эцэг тэднийг ямар хүмүүс болоосой гэж хүсэн хүлээдгийг ойлгох ёстой. Ийнхүү ойлгоход бид тэдэнд яаж туслах вэ?

Бид гэр бүлийн үдэш, гэр бүлийн хурал эсвэл хүүхдүүдтэйгээ сайн мэдээнд тулгуурласан нухацтай яриа өрнүүлэх үед тэдний өөдөөс эгцлэн харж, тэднийг хайрладгаа, бас Тэнгэрлэг Эцэг тэдэнд хайртайг хэлэх боломж бидэнд бий. Түүнчлэн энэхүү торгон агшинд бид тэднийг хэн бэ гэдгийг, тэд энэ дэлхийд, бас дэлхийн гэр орондоо ирж, гэр бүлээрээ үүрд хамт байхын төлөө ариун сүмүүдэд гэрээнүүд хийдэг нь тэдний хувьд ямар их азтай учрал болохыг зүрх сэтгэлээрээ ойлгоход нь тусалж чадна. Хүүхдүүдтэйгээ хамт өнгөрүүлдэг хором бүрд бид сайн мэдээний зарчим болон адислалуудаас хуваалцаж, үлгэр жишээ үзүүлж чадна.

Энэхүү ороо бусгаа цаг үед манай өсвөр үеийнхэн зөв зүйлийг зөвхөн *мэддэг байх нь* хангалтгүй юм. Харин тэд мэддэг зөв зүйлээ *идэвхтэй хэрэгжүүлэх* ёстой. Ёслол, чуулгын үйл ажиллагаа, сүнслэг нөлөө бүхий хөтөлбөрүүд, идэвхжүүлэх үйл ажиллагаануудад чин сэтгэлээсээ, идэвхтэй оролцох нь Бурханы хуяг дуулгыг өмсөхөд залуучуудад тусалдаг. Бэрхшээлийн галт сумнаас хамгаалах хуяг дуулгыг өмсөхөд нь бид тэдэнд тусалж чадах уу? Залуучууд Их Эзэний замыг жинхэнэ ёсоор сонгохын тулд Түүний замыг мэдэх ёстой. Түүний замыг жинхэнэ ёсоор мэдэхийн тулд хэрхэн идэвхтэй ажиллаж, үйл ажиллагаануудад оролцохыг бид тэдэнд зааж, сургах ёстой.

Хамгийн агуу номлолын ажил ямагт бидний гэр оронд байх болно. Бидний гэр орон, чуулга, ангиуд бол номлолын талбарын нэг хэсэг юм. Бидний хүүхдүүд, ач зээ нар бол бидний хамгийн чухал сонирхогчид.

Номлолын хамгийн агуу ажил ямагт гэр оронд байх болно. Энэ бол өсвөр насны хүүхдүүдээ тэдний дуулгавартай байдлаар дамжуулан сүнслэг байдлын хувьд бэлтгэлтэй болгож, хойч үеийн гэр бүлүүдээ мөнхөд хадгалан үлдээхэд анхаарлаа төвлөрүүлэх явдал мөн.

Авралын хамгийн агуу ажил, хамгийн агуу үйл ажиллагаа бидний гэр оронд байх болно. Хэрвээ танай гэр бүлийн хэн нэгэн нь өөр замыг сонгон будилж яваа бол та Сүмийн хамгийн чухал авралын ажилд оролцогч, аврагч болж байгаа нь тэр.

Гагцхүү бууж өгсөн үед л ялагдал ирдгийг би хувийнхаа туршлагаар гэрчилж байна. Эхлэхэд оройтох буюу эртдэх гэж хэзээ ч байдаггүй. Өмнө нь юу болсон талаар бүү санаа зов. Утасд, захидал бич. Очиж уулз. Гэртээ ирэхийг урь. Айж, ичих хэрэггүй. Таны хүүхэд бол Тэнгэрлэг Эцэгийн хүүхэд. Та Түүний ажлыг хийж байгаа. Тэрээр хүүхдүүдээ цуглуулна гэж амласан бөгөөд Тэр тантай хамт байдаг.

Бидний хамгийн агуу итгэл гэр оронд маань байсан цагт бид эцэг эх байхын хүнд сорилт, бэрхшээлүүдийг даван туулах хүч чадалтай байх болно.

Ерөнхийлөгч Монсон хэсэг эхчүүдэд хандан, “Бид заримдаа амжилт ололт, бүтэлгүйтлийнхээ үр дүнг үнэлэх гэж хэт яардаг. Нэмж хэлэхэд, өнөөдрийн сорилтыг үүрдийнх юм шиг бүү бод. Тэнгэрлэг Эцэг ажил үйлсээ алсын хараатайгаар төлөвлөн хэрэгжүүлдэг. Их Эзэн, “Ирээдүйд орших их зүйл тэнд буй. . Тиймийн тул...өөрсдийн хүчинд байгаа бүх зүйлийг зоригтойгоор хийцгээе; мөн тэгээд бат итгэлтэйгээр зогсож Бурханы авралыг харна, мөн учир нь түүний гар илчлэгдэх болно” (С ба Г 123:15, 17) гэжээ.

Бурхан амьд, Есүс бол Христ мөн гэдэг гэрчлэлээ хэлэх боломж Христийн амилалтын баярын энэ ням гарагт бидэнд байгаа гэдэгт би итгэлтэй байна. Бидний зүрх сэтгэл юунд зориулагддагийг болон үр хүүхдээ хайрладаг бидний хайрыг хүүхдүүд маань мэддэг байхын төлөө бид гэрчлэлээ хуваалцдаг байхад би бүрэн итгэлтэй байна. *Хамгийн агуу хайр, хамгийн агуу зааж сургах ажил бидний гэр оронд байх ёстой,*

Их Эзэний адислал эцэг эхчүүдэд, итгэлтэй гэр бүлүүдэд төрж, өсч хүмүүжиж байгаа залуучуудад ирэхийн төлөө, тэд гэр бүлдээ хайраар хүрээлүүлж, удирдан чиглүүлэгдэхийн баяр баяслыг ойлгодог байхын төлөө би гуйж байна. Бидэнд мөнхийн гэр бүлүүд байхын төлөө, Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христ хоёрын дэргэд бид бүгд үүрд хамтдаа амьдрахын төлөө би залбирч байна.

Есүс Христ амьд гэдгийг би онцгойлон гэрчилж байна. Тэр бол алдагдсан хонинуудын хоньчин, төөрсөн бодгалийн аврагч, шархалсан зүрхийг эдгээгч, бүх хүн төрөлхтний найдвар мөн. Бидний Эзэн Түүнтэй хамт бид бүгдийг хайрладаг мөнхийн хайранд нь итгэх итгэлээр Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлцгээе гэж би Есүс Христийн нэрээр залбирч байна, амен.

ЭШЛЭЛ

1. “Maud Muller,” *The Complete Poetical Works of John Greenleaf Whittier* (1876), 206-г үз.